


2015 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ТОЙМ СУДАЛГАА

ГАРЦ Эдийн засагчдын уулзалтын
хэлэлцүүлэгт 2014.11.15

А.Батпүрэв (MScEc.)

Бүтээгдэх баялгийн 100 төгрөг тутмаас 30-ийг төр дахин хуваарилна



- Макро эдийн засгийн нилээд өөдрөг хүлээлтэд үндэслэсэн ДНБ, Төсвийн орлогын төсөөлөл.
- ЭЗ-ийн өсөлт 7%, Төсвийн орлого 16% /2014 гүйцэтгэлээс/, Татварын бус орлого 76% үүнд өмч хувьчлал 6.3 дахин, хүү торгууль 3.6 дахин, ноогдол 2.9 дахин
- “Төсвийн орлогын бүтэц нь гадаад орчны нөлөөлөл, бизнесийн үйл ажиллагааны эцсийн үр дүнгээс хамаарч огцом өөрчлөгддөг тогтвортой буй эх үүсвэр давамгайлсан улмаар тогтвортой бус байдлыг нөхцөлдүүлсэн өрөөсгөл шинж чанартай байна.” /ҮАГ, 2014/


Орлогын эх үүсвэр татвараас бүрдсэн хэвээр



- Нийт орлогын 82% татварын орлогоос, 17% татварын бус үрсгал орлогоос бүрдэж байгаа бөгөөд хөрөнгийн орлого ойролцоогоор 1% эзэлж байна.
- Татварын бус орлого хэдийгээр огцом нэмэгдсэн мэт боловч төлөвлөгдсөн өмч хувьчлал /МИАТ, Хөтөл/ хасвал 10% өсөлт буюу татварын орлогын өсөлтөөс 3% бага байна.

Татварын ачаалал үнэхээр буурсан уу..?

Эдийн засаг дах татварын ачаалал
(Татварын орлогын ДНБ-д эзлэх хувиар)



ДНБ-ы нэрлэсэн өсөлт ба татварын орлогын харьцуулалт



- 2014 оны төсвөөр татварын орлогын ДНБ-д эзлэх хувь 31% байхаар төлөвлөгдсөн ч гүйцэтгэл 24% орчим гарахаар байгаа бөгөөд аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин буурснаас татварын орлого их хэмжээгээр тасарч байна.
- Эсрэгээрээ татварын хяналт, шалгалтын дарамт нэмэгдсэн

Татварын бааз суурь хумигдаж байна

Мянган аж ахуй нэгж, Ашигт ажиллагаа(%)




Д.Баярмаа нар: Монгол улсын 2015 оны нэгдсэн төсөвт хийсэн тойм дүгнэлт. 2014. Нээлттэй Нийгэм Форум

- Эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор сүүлийн 4 жилд нийт аж ахуйн нэгжийн тоо 12 хувиар нэмэгдсэн ч ашигтай ажилладаг компанийн тоо 3% буурчээ.

Хувь хүмүүсийн татварын орлогод эзлэх хувь нэмэгдэж байна


Татварын орлогын бүтэц
(гадуур тойрог 2015, дотуур тойрог 2014 он)



- Хувь хүний орлогын татварын орлого
- Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
- Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж
- Өмчийн татвар
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Онцгой албан татвар
- Тусгай зориулалтын орлого
- Гаалийн албан татвар
- Бусад татвар (төлбөр, хураамж)

Эх сурвалж.

Хувь хүний орлогын татварын орлого
(тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: СЯ, 2014.11

- Татварын нийт орлогод хувь хүний орлогын татвар, нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн эзлэх хувь эрс нэмэгдэж ААНОАТ, төлбөр хураамжуудын эзлэх хувь багасахаар байна.
- Цалингийн өсөлт VS Ашигт ажиллагаа
- Татвар төлөгч нэг иргэнд ногдох ХАОТ 452 мянган төгрөг.

Татварын зардал нэмэгдэж байна

Хүснэгт. Татварын орлого, татварын зарлага /тэрбум төгрөг/


Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 оны эхний хагас жил гүйц	2014 ХБГ	2015 төл
Нийт татварын орлого	4,203.3	5,072.8	2,322.4	5,217.4	5,900.5
Нийт татварын зарлагын хэмжээ	316.0	474.8	460.4	851.2	911.6
<i>Нийт татварын зарлагын татварын орлогод эзлэх хувь</i>	7.5%	9.4%	19.8%	16.3%	15.4%

Сангийн яам, 2014. Монгол улсын 2015 оны нэгдсэн
төсвийн танилцуулга


- Сүүлийн 4 жилд татварын хөнгөлөлт чөлөөлт үзүүлэх 55 шинээр нэмэгдэж 14 хасагдсан.
- Гэвч нийт татварын зардлын 80 хувийг НӨАТ-ын чөлөөлөлт эзэлж байгаагаас жижиг, дунд бизнесийн орчныг сайжруулсан гэж үзэхэд эргэлзээтэй.

Нэг салбараас хамаарах хамаарал буурсан уу...

График. Уул уурхайн орлогын
нийт орлогод эзлэх хувь



Сангийн яам, 2014. Монгол улсын 2015 оны нэгдсэн
төсвийн танилцуулга



- Уул уурхайн бүс салбарын өсөлтийн хүлээлт өндөр /21%/
- Уул уурхайн салбарын үналтыг дагаад төсвийн орлого их хэмжээгээр агшиж байгаа.
- Уул уурхайн бүтээгдэхүүн гаргалтыг маш өндрөөр төлөвлөсөн. /Оюутолгойн 2-р шат, нүүрсний нийлүүлэлтийн өсөлт... /

Уул уурхайн салбараас төсөвт үзүүлэх нөлөө өндөр хэвээр

1	Валютын ханш 10 төгрөгөөр өөрчлөгдөхөд	7,674.8
2	Нүүрсний үнэ 1 ам.доллараар өөрчлөгдөхөд	2,048.9
3	Нүүрсний хэмжээ 1 сая тонноор өөрчлөгдөхөд	8,318.8
4	Зэсийн үнэ 10 доллараар өөрчлөгдөхөд	913.7
5	“Оюу Толгой” ХХК-ий экспортлох зэсийн баяжмалын хэмжээ 1,000 тонноор өөрчлөгдөхөд	1,728.4
6	“Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн экспортлох зэсийн баяжмалын хэмжээ 1,000 тонноор өөрчлөгдөхөд	2,456.9
7	Алтны үнэ 10 ам.доллараар өөрчлөгдөхөд	702.8
8	Алтны тушаалт 1 тонноор өөрчлөгдөхөд	1,968.8
9	Импортын хэмжээ 1 сая ам.доллараар өөрчлөгдөхөд	241.0

Сангийн яам, 2014. Монгол улсын 2015 оны нэгдсэн төсвийн танилцуулга

Орлогын хэсгийн дүгнэлт

- Макро эдийн засгийн ихээхэн өөдрөг хүлээлтэд суурилсан.
- Төсвийн нэг салбараас хамааралтай, эмзэг байдал буураагүй бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнийг “тэнцвэржүүлсэн үнэ”-р тооцдог болсон ч экспортын хэмжээг өндрөөр төлөвлөсөн.
- Татварын зардал нэмэгдсээр байна.
- Цөөн тооны салбар, тэдгээрийг төлөөлсөн цөөн татвар төлөгчдөд төвлөрсөн төсвийн орлогын бааз суурь, хамрах хүрээг өргөжих бус хумигдаж байна.
- Цалингийн өсөлтийг дагаад хүн амын орлогын албан татвар төвлөрүүлэлт нэмэгдэж байгаа ч эдийн засгийн бодит өсөлттэй холбоогүй мөн жигд, шударга ноогдохгүй байна.
- Хөрөнгийн татварын өсөлт ийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судлах шаардлагатай.

Эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж байна




Эх сурвалж: СЯ, 2014.11

- Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь жил бүр хэлбэлзэж ирсэн хэдий ч сүүлийн дөрвөн жилийн хандлага өсөх чиглэлтэй байна.
- Төсвийн зарлагын хөшүүргийн нөлөө нь эдийн засгийн өсөлтөд бодитой нөлөө үзүүлж чадаж байгаа эсэх эргэлзээтэй, нарийвчлан судалж салбар чиглэлүүдийг эрэмжлэх шаардлагатай.

Зарлагын тэлэлтийг зогсоох шаардлагатай


Төсвийн зарлага, эдийн засгийн өсөлт, инфляцийн харьцуулалт




Эх сурвалж: СЯ, 2014. 11

- Сүүлийн 10 жилийн ихэнхид төсвийн зарлагын өсөлт нь тухайн жилийнхээ эдийн засгийн бодит өсөлт болон инфляцийн нийлбэрээс илүү их хувиар нэмэгдэж иржээ. Өөрөөр хэлбэл төсвийн зарлага бүтээгдэж буй нийт баялгийнхаа өсөлтөөс хурдтай нэмэгдэж байсан.

Урсгал зардлын тэлэлт үргэлжилж хөрөнгө оруулалт хумигдсан




Эх сурвалж: СЯ, 2014. 11



Эх сурвалж: СЯ, 2014. 11

- 2015 оны төсвийн төслөөр нийт зардал 4.8 хувиар өсөхөөр байгаа нь эдийн засгийн өсөлттэй уялдаж байгаа боловч задалж үзвэл урсгал зардал 20% нэмэгдэж хөрөнгө оруулалтын зардал Хөгжлийн банкны санхүүжилтийг тооцохгүй бол 50% буурахаар байна.


Орон нутгийн төсөв эрс нэмэгдсэн ч чадавхи улам суларсан байна



2015 оны төсвийн төсөл



Орон нутгийн төсвийн тэнцэл

(сая төгрөгөөр)



2013 оны төсвийн төсөл

Аймаг, хотуудын төсөв тэгш бус байна




- Зарим хувьсах зардлыг орон нутгийн төсөвт шилжүүлэн олгохоор болсноор орон нутгийн төсвийн харилцан адилгүй хуваарилалт эрс багассан.
- Нэг иргэнд ноогдох төсвийн энэхүү хазайлт нь газар зүйн байршилтай хамааралгүй байна.

Зарлагын хэсгийн дүгнэлт


- Зарлагын тэлэлт хумигдсан хэдий ч урсгал зардлын өсөлт өндөр хэвээр бөгөөд хөрөнгө оруулалтын зардал багасч байна.
- Төсвийн зарлага дахь урсгал зардлын хувь хэмжээ өндөр, түүн дотроо цалингийн болон бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь буурахгүй байна.
- Олон тооны тусгай сан бий болж маш их хэмжээний мөнгө зарцуулж байгаагийн дийлэнхи нь санхүүгийн хувьд үр ашиггүй, төсвийн татаасаар санхүүждэг хэвээрээ байна.
- Орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг бууруулах чиглэлд томоохон дэвшил болсон. Гэхдээ аймгуудын төсвийн чадавхи, нөөц бололцоо суларсан байна.
- Орон нутгийн төсвийн нэг хүнд ногдох зардлын хэмжээ эрс багассан ч сургууль, эмнэлэг зэргийн хувьсах зардалыг хасвал жигд бүс хэвээр бөгөөд газар зүйн байрлал, төсвийн чадавхи зэргээс хамаарахгүй байна.
- Хөрөнгө оруулалтууд өмнөх амлалтуудыг гүйцээхэд чиглэж байгаа. /ХБ-аас бусад/

Төсвийн төлөвлөлт тогтворгүй явж иржээ



- Төсвийн урсгал болон нийт тэнцэл буурах талдаа гадаад эдийн засгийн нөхцлөөс өндөр хамааралтай боловч эдийн засаг өсөх чиглэлд дагаж сайжрах хамааралгүй байна.
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль алдагдлыг хязгаарласан.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд өрөөс өөр эх үүсвэр ашиглахгүй байна



Эх сурвалж: СЯ, 2014.11

- 2010-2012 онд авсан 590 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөр сүүлийн 3 жилийн төсөвт дарамт учруулж байна гэж үзэж болохоор харагдаж байна.

Төсвийн эмзэг байдал өндөр байна

Төсвийн эмзэг байдлын шалгуур үзүүлэлтүүд, Үнэлгээний үр дүн				
Шалгуур үзүүлэлт	Эмзэг байдал бага	Эмзэг байдал дунд	Эмзэг байдал өндөр	Үнэлгээ
Үндсэн тэнцэл/ДНБ	>1.5%	1.5; -1%	<-1%	Эмзэг байдал өндөр: 2015 онд -2% , 2014 онд -1.9%
Улсын өр/ДНБ	<25%	25-60%	>60%	Эмзэг байдал дунд: 2015 онд 49.3% , 2014 онд 39.7%
Санхүүжилтийн эх үүсвэрийн хэрэгцээ	<5%	5-12%	>12%	Эмзэг байдал бага: 2014 онд 4.9%, 2015 оны төслөөр 3.6%
Зайлшгүй зардал/Нийт зардал	<50%	50-70%	>70%	Эмзэг байдал өндөр болж нэмэгдэнэ. 2014 онд 70%, 2015 оны төслөөр 80%
Түүхий эдийн орлого/Нийт орлого	<10%	10-20%	>20%	Эмзэг байдал өндөрөөс дунд болж буурч байна. 21% - 16%

Төсвийн богино хугацааны эрсдэл багагүй

Орлогын төлөвлөгөө тасрах эрсдэл...

Татварын орлогын төлөвлөлт нь эдийн засаг ирэх онд нэрлэсэн дүнгээр 11 хувь, бодит дүнгээр 7 хувиар өснө, гол нэрийн түүхий эдийн үнэ “тэнцвэржүүлсэн” үнээс багагүй байна гэсэн таамаглалд суурилж байгаа.

Гадаад эдийн засгийн нөхцөл байдал үүн дотроо эрдэсийн зах зээл тааламжгүй байх нь тодорхой байгаа нөхцөлд ийм хэмжээний өсөлт нь нилээд өөдрөг төсөөлөлд орох бөгөөд ингэж төлөвлөх гол үндэслэл нь 2 жилийн өмнө төлөвлөж байсан ч одоо ч тодорхойгүй байгаа Оюутолгойн ордын 2 дахь шатны хөрөнгө оруулалт, олборлолттой холбоотой байна.

Зарлагын өсөлтийн эрсдэл...

2015 оны төсөв нь зардал талдаа эрсдлийг тооцоолоогүй бөгөөд зардал бууруулах аливаа оролдлого нь төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйцээр урсгал зардал голлосон байна. Нөгөө талаас төсвийн зардал нь ихээхэн доогуур тооцолсон инфляци, валютын ханшийн хүлээлтэд суурилсан байгаа.

Тэнцлийн хэсгийн дүгнэлт

- Тэнцвэржүүлсэн ашиг, алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй байх хууль зүйн орчин бүрдсэн нь төсвийн тогтвортой байдлыг хангахад чухал алхам болсон ч Төсвөөс гадуурх их хэмжээний зардал нь улсын санхүүгийн эрсдлийг нэмж байна.
- Засгийн газрын өрийн дарамт хэвийн түвшинд байгаа ч жилээс жилд нэмэгдэж байна. Үүн дотроо гадаад өрийн хувь хэмжээ буурахгүй байгаа.
- Хуулиар тогтоосон шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд төлөвлөгдсөн ч зарим үр дүнгийн үзүүлэлт зохистой түвшнээс муудах магадлал өндөр.
- Төсвийн эмзэг байдал бүхэлдээ өндөр.
- Ихээхэн өөдрөг төсөөлөлд суурилсан төлөвлөгөөний улмаас төсвийн орлого төсөвлөснөөс бага байх эрсдэл бодитой байна.
- Мөн инфляци, валютын ханш ЗГ-ын хүлээж буй нам түвшнээс өндөр байх тохиолдолд төсвийн зарлагын хэвийн байдал алдагдах эрсдэл байна.
- Гол нэрийн түүхий эдүүдийн үнийг тэнцвэржүүлсэн аргачлалаар тооцож эхэлснээр үнийн хэлбэлзлийн эрсдэл багасчээ.